

Гадаадын иргэн, харьяатын газрын
2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
01/2243 дугаар албан бичгийн хавсралт

“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот

2025 оны 12 дугаар сарын 10

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/
				Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 2.7.Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.							
2.7.3.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	2025 онд 490.0	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2024	Шинэчлэн хөгжүүлэх программ хангамжийн тоо-1	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна	Монгол Улсад 2025 оны 11 дүгээр сарын байдлаар хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй 37097 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 22868 иргэн, цагаачлан оршин суух 1767 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 1230 иргэн бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.4, 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй. https://opendata.gov.mn/data ЦХИХХЯ, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг 2023 оны 11 дүгээр сард холбосон ба 2025 онд үйлчилгээ үзүүлэх 3 гэрээг ЦХИХХЯ-тай байгуулж, 6 байгууллагын 32 төрлийн сервисээр мэдээлэл авч, 25 байгууллагад 13 сервисээр мэдээлэл өгч, 08 дугаар сард хуулийн этгээдийн лавлагаа болон даатгуулагчийн сүүлийн 36 сарын нийгмийн даатгалын лавлагааны сервисийг холбон бүртгэл, мэдээллийн асуудлаар төрийн байгууллага хоорондын уялдааг хангасан. Мөн системээр гадаадын иргэнд хяналт тавих, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай хангаж, виз, оршин суухын мэргэжилтэн, хяналтын улсын байцаагчид хяналт шалгалт болон бүртгэлээр хяналт

(АЛСЫН ХАРАА-2050) 2025-IY (1)Y

1	2	3	4	5	6	7	8
							тавьж байна. Системийг нэвтрүүлснээс хойш 1035 удаагийн шинэчлэлээр сайжруулан гадаадын иргэний виз, бүртгэлтэй холбоотой 132594 удаагийн хүсэлтээр 261242 иргэний баримт материалыг авч, хянан шийдвэрлэлээ. Системд нэмэлт хөгжүүлэлт хийх 120.0 сая төгрөгийн ГИХГ/20250103004/01/06-18 дугаар гэрээг гүйцэтгэгчтэй байгуулж, дүгнэн хүлээн авсан боловч төсөв татагдсанаар гэрээний санхүүжилтийг олгоогүй байна. Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний оршин суух үнэмлэх хэвлэх 170.6 сая төгрөгийн өртөгтэй 4 төхөөрөмжийг орон нутгийн төсөв болон гадаадын тусламжаар нэмэгдүүлсэн. https://isf.mn/ Олон улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газруудын мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны ХУР системд дамжуулах сервисийг хөгжүүлж, тайлант хугацаанд бүртгэлтэй нийт 83 байгууллагаас 30 байгууллага нь тоон гарын үсэг авч ашиглаж байна. FS100115_NonGovernmentHeadInfo
Үнэлгээ 100 хувь							